

Агуулга

1. ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
2. “ ЦАГААН ЧУЛУУТ-1 ” АЛТНЫ УУРХАЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДАЛ	3
2.1 Төсөл хэрэгжих орчны өнөөгийн төлөв	9
2.2 Төслийн гол ба болзошгүй нөлөөлөл.....	13
3. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙ ЖИЛИЙН ГОЛ ЗОРИЛТ	14
3.1 Байгаль хамгаалах төлөвлөгөө	16
3.1.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө:.....	146
3.1.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө:.....	19
3.1.3 Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө:.....	20
3.1.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө:.....	22
3.1.5 Түүх соёл, шинжлэх ухааны дурсгалт зүйлс.....	22
3.1.6 Химийн бодис эрсдэлийн менежментийн төлөвлөгөө:	22
3.1.7 Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө.....	22
3.1.8 Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө.....	24
3.1.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	25
3.1.10 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө.....	28
3.1.11 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө.....	29
3.2 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулах нийт зарда.....	30

Хүснэгтийн жагсаалт

1. Товч танилцуулга

Уг төсөл нь Улаанбаатар хотоос 700 км, Чойбалсан хотоос баруун хойш 200 км, Баяндун сумаас зүүн хойш 30 км-т Дорнод аймгийн Баяндун сумын нутагт орших ба MV-015436 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий Цагаанчулуут-1 талбайд орших “Жалга-10, 10а” алтны шороон орд нь х ба 1:100 000-ны масштабтай байр зүйн зургийн М-49-95 тоот хавтгайд орших бөгөөд 456.68 га талбайг хамарна.

MV-015436 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийг анх АМГ-ын ГУУКадастрын хэлтсээс “Эс Жи Групп” ХХК-д 2010 оны 01-р сарын 25-ны өдөр 456.68 га талбайтайгаар олгосон ба 2010 оны 05-р сарын 27-ны өдөр ГУУКХэлтсийн даргын №608 тоот шийдвэрээр 456.68 га талбайг бүхэлд нь “Эс Жи майнинг эрдэс” ХХК-д шилжүүлсэн байдаг. Улмаар 2015 оны 06-р сарын 12-ны өдрийн АМГ-ын Кадастрын Хэлтэсийн даргын №473 тоот шийдвэрээр “Эс Жи гоулд майнинг” ХХК-д бүхэлд нь шилжүүлсэн байна.

Тус талбайд 2021 онд хайгуулын ажлыг хийж гүйцэтгэн үр дүнгийн тайлан боловсруулж 2023 онд Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн алтны нөөцийг хими цэврээр бодитой В зэргээр 15.22 кг, боломжтой С зэргээр 3.46 кг, ордын хэмжээнд бодитой болон боломжтой В+С зэрэглэлээр 18.68 кг алт байгааг тооцон нөөцийг улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт орших Цагаанчулуут-1 талбайд орших “Жалга-10, 10а” MV-015436 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах бодитой болон боломжтой В+С зэрэглэлээр хими цэврээр 18.68 кг алт байгаад тулгуурлан уг ордыг 1 жил ашиглах ТЭЗҮ-ийг төсөл боловсруулан батлуулсан байна.

Цагаанчулуут худгийн “Жалга-10” “Жалга-10а” нэртэй алтны шороон ордыг ил ашиглах төслийн БОАЖЯ-наас 2024 оны 02 дугаар сарын 27-ний өдрийн 06/917 тоот албан тоотоор гарсан байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээний дүгнэлтэд заасан чиглэл, хуваарийн дагуу Байгаль орчны мэргэжлийн байгууллага “Дөрвөн талст экологи” ХХК нь төслийн үйл ажиллагаанаас тухайн нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгэм, оршин суугчдын эрүүл мэндэд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг тодорхойлох, үнэлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, зайлсхийх, бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөн, хэрэгжүүлэх БОННҮнэлгээний тайлан боловсруулсан

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуй нэгж байгууллагын нэр

“ЭС Жи гоулд майнинг” ХХК

Улсын бүртгэлийн гэрчилгээ 9011465066

Регистрийн дугаар 5806771

Төсөл хэрэгжүүлэгчийн хаяг

Улаанбаатар хот, Хан уул дүүрэг, 11-р хороо 3 хэсэг 301 байр 202 тоот

Утас: 99105268 , 99857501


ХҮСНЭГТ 1. MV-015436 тоот тусгай зөвшөөрлийн цэгийн солбицол

№	Уртраг			Өргөрөг			UTM	
	Градус	Минут	Секунд	Градус	Минут	Секунд	Өргөрөг	Уртраг
1	113	26	2.1	49	27	41.95	676363.511	5481625.198
2	113	26	1.96	49	30	2.01	676220.954	5485949.810
3	113	25	12.01	49	30	2.01	675216.451	5485917.436
4	113	25	12.11	49	29	42.95	675237.375	5485328.973
5	113	24	55.62	49	29	42.95	674905.722	5485318.325
6	113	24	54.66	49	29	31.7	674897.554	5484970.333
7	113	25	3.1	49	29	31.52	675067.491	5484970.222
8	113	25	2.03	49	29	9.72	675067.573	5484296.399
9	113	25	11.46	49	29	9.54	675257.447	5484296.932
10	113	25	10.15	49	28	42.81	675257.607	5483470.729
11	113	25	12.16	49	28	42.77	675298.086	5483470.793
12	113	25	10.83	49	28	16.58	675297.302	5482661.251
13	113	25	12.81	49	28	16.54	675337.184	5482661.295
14	113	25	12.03	49	28	0.7	675337.199	5482171.692
15	113	25	17.49	49	28	0.58	675447.196	5482171.517
16	113	25	17.11	49	27	41.95	675458.036	5481596.024
17	113	26	2.1	49	27	41.95	676363.511	5481625.198

Зураг 1. Төсөл хэрэгжих талбайн зураг



Зураг 2. Төслийн талбайн байрзүйн зураг



Төслийн хүчин чадал, техник технологи Олборлолтын ажлын хүчин чадал, ажиллах горим

Уурхайн жилийн хүчин чадлыг үндэслэхдээ уул техникийн нөхцөл, захиалагч байгууллагаас өгсөн уг төслийг боловсруулах техникийн даалгавар зэргийг харгалзан жилд 116.9 мян.м³ элс олборлон баяжуулахаар тооцлоо.

Иймээс ил уурхайн нийт ажиллах хугацааг 1 жил байхаар энэхүү техник эдийн засгийн үндэслэлийн уулын ажлын календарь төлөвлөгөө болон техник эдийн засгийн тооцоог боловсруулав

Ил уурхайн хэмжээсүүд

Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоогоор 0.194 г/м³ дундаж агуулгатай В' зэргийн блокуудын нийт талбай 91.4 мян.м², хуулах хөрсний хэмжээ 241.04 мян.м³, олборлон баяжуулах элсний хэмжээ 116.9 мян.м³, нийт уулын цулын хэмжээ 357.9 мян.м³, алтны нөөц шлихээр 22.67 кг, хими цэврээр 18.68 кг тус тус болж байна. Ашигт малтмалын хучаас хөрсний зузаан 2.8 м, элсний зузаан 0.8 м, блокийн өргөн дунджаар 90 м байна.

Хүснэгт 2. Ил уурхайн хэмжээсүүд

№	Хэмжигдэхүүнүүд	Ордын дундаж үзүүлэлт
1	Шимт хөрс хуулалтын доголын өндөр	0.2-0.3 м
2	Хөрс хуулалтын доголын өндөр	2.5 м
3	Элс олборлолтын доголын өндөр	1.0 м
4	Доголын налуугийн өнцөг	60 ⁰
5	Авто замын өргөн	8 м
6	Авто замын налуугийн хэмжээ	60-80 %
7	Ил уурхайн ёроолын хамгийн бага өргөн	10 м
8	Ил уурхайн хажуугийн өнцөг	60 ⁰
9	Ил уурхайн нийт гүн	3.8 м

Уурхайг нээх ба ашиглах

Уурхайг нээх. Уурхайн нээлтийг В'-1-1-1 блокоос налуу гадаад траншей нэвтэрч эхлэн хөрс хуулалтын ажлыг эхлүүлэхээр тооцоолж байгаа ба элс олборлолт болон баяжуулалтын ажил хөрс хуулж эхэлсний дараагаас эхлэн явагдана.

Шимт хөрс болон хөрсийг хуулсаны дараагаар уурхайн тоног төхөөрөмжүүд орж гарах болон элс тээвэрлэх автосамосвалууд зөрж, чөлөөтэй нэвтэрч байхаар налуу траншей буюу

орлыг байгуулна. Нэгч траншейн эзлэхүүнийг доорх байдлаар тооцлоо.

Олборлолт эхлэх хэсэгт элс угаах төхөөрөмж, түүнийг тэжээгч утгуурт ачигч болон бусад тоног төхөөрөмжүүдийн үйл ажиллагааг тасралтгүй хангах нөхцөлийг бүрдүүлэх үүднээс хөрсийг хуулсан байх шаардлагатай. Энэ шаардлагыг хангахын тулд хөрс хуулалтын ажлыг элс олборлож, угааж эхлэхээс өмнө эхлүүлэхээр төлөвлөж байна.

Ордыг ашиглах. Хөрс хуулалт, олборлолтын ажил эхлэхийн өмнө үржил шимт хөрс буюу гадаргаас ойролцоогоор 0.2-0.3 м орчим зузаантай хэсгийг бульдозероор түрж ашиглалтын гадна талаар саад болохооргүй зайд овоолго үүсгэнэ. Энэ нь нөхөн сэргээлт хийх ажлын төгсгөлд үржил шимт хөрсөөр буцаан хучих нөхцөлийг хангаж өгнө.

Уурхайн ажиллах горим

Уурхайн ажиллах горим нь манай орны улирлын шинж чанар, цаг агаар, уур амьсгал, ил уурхайн жилийн хүчин чадал зэргээс шалтгаална. Уурхай нь ашиглалтын 1 жилтэй байх бөгөөд жилд 199 хоног ажиллахаар тооцлоо. Уурхай нь улирлын чанартай үйл ажиллагаа явуулах учир олборлолт явуулах үед тасралтгүй ажиллана. Улсын чанартай баяр ёслолын өдрүүдэд амарна. Харин техник, тоног төхөөрөмжүүдэд үзлэг үйлчилгээ, урсгал засвар хийх хоногийн тоо сард 2 өдөр байхаар төсөлд тооцооллоо.

Хүснэгт 6. Уурхайн ажиллах горим

д/д	Нэрс	Хэмжих нэгж	Жил тус бүр
1	Жилд ажиллах боломжит хоног	хоног	199
2	Амралт, баяр ёслол	хоног	6
3	Цаг агаарын хүндрэл	хоног	8
4	Уурхайн ажиллах ажлын өдөр	хоног	185
5	Урсгал засвар хийгдэх	хоног	12
6	Уурхайн бэлтгэл ажил	хоног	15
7	Хөрс хуулах боломжит хоног	хоног	180
8	Элс угаах боломжит хоног	хоног	175
9	Хоногийн ээлжийн тоо		2
10	Нэг ээлжийн үргэлжлэх хугацаа	цаг	12

Уулын ажлын календарьчилсан төлөвлөгөө

Цагаан чулуут худгийн Жалга-10, 10^а алтны шороон ордын уулын ажлын календарьчилсан төлөвлөгөөг захиалагчаас өгсөн техникийн даалгаврын дагуу дараах байдлаар төлөвлөж байна.

Хүснэгт 7. Уулын ажлын төлөвлөгөө

Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Жилд
Хөрс хуулалт	мян.м ³	241.04
Элс олборлолт	мян.м ³	116.9
Дундаж агуулга	мг/м ³	194
Алт /шлих/	кг	22.67
Алт /хими цэвэр/	кг	18.68

Ил уурхайн ашиглалтын систем

Уг орд нь ашиглалтын гүн их биш, уул-геологийн нөхцөл харьцангуй энгийн тул ил уурхайн гадаад болон дотоод овоолго бүхий авто тээвэртэй ашиглалтын системээр ашиглах нь хамгийн тохиромжтой юм. Иймд шимт хөрсийг хуулсаны дараагаар хөрс, элсний давхаргыг экскаватор автосамосвалын хослолоор, хөрсийг эхний үед хөрсний гадаад овоолгод тээвэрлэх ба элс олборлосны дараагаар дотоод овоолго үүсгэхээр төлөвлөлөө. Харин алт агуулсан элсийг скруббер байрласан талбайд зөөвөрлөхөөс гадна скрубберээр угаагдан гарсан эфель, галийг бульдозероор түрж, тэгшлэн хэлбэршүүлж өнгөн хөрсөөр хучиж нөхөн сэргээлт хийнэ.

Хөрс болон шимт хөрсний давхаргуудыг холихгүйгээр буцааж нөхөн сэргээлтийн ажлыг хийх боломжтой болох юм. Уурхайд хийгдэх процессуудын дараалал:

- Үржил шимт өнгөн хөрс хуулах
- Хөрс хуулах
- Элс олборлох
- Элс угаах (баяжуулах)
- Хөрсний дотоод овоолго үүсгэх түүнийг тэгшлэх
- Техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх.

Уурхайн бэлтгэл ажлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

- Ажилчдын амьдрах тосгон байгуулах
- Тээврийн хэрэгсэл зорчих зам, гүүр бэлдэх
- Сэлбэг хэрэгсэл, шатахуун тосны агуулах сав бэлдэх
- Угаах төхөөрөмжийн ажиллагаанд шаардагдах усан сан, угаасан булингыг хуримтлуулах хиймэл нуурын котлован байгуулах
- Угаах төхөөрөмжийг угсрах г.м ажлуудыг хийж гүйцэтгэнэ.

2. “Цагаан чулуут-1” алтны уурхайн байгаль орчны төлөв байдал

2.1 Төсөл хэрэгжих орчны өнөөгийн төлөв

Уур амьсгал: Дорнод аймаг нь далайн түвшнээс дээш 580-1000 метр өргөгдсөн, ухаа гүвээ, тэгш талархаг гадаргатай. Аймгийн баруун хойд талаараа Хэнтийн нурууны салбар Эрээн давааны нуруу, Цагаан даваа, Бумбатын даваа, Энх, Жаварт хошуу, Дэл, Онцгой, Хараат, Бүрэнхаан уул, Эрдэнэ-уул, хойд болон зүүн хойд талаараа Хурам хан уул, Шивээт уул, Хөх уул, Модот уул, Хөгнө, Мардай, баруун талаараа Өгөөмөр уул, Баян хан уул, Өвөр уртын уул, баруун өмнө талаараа Матад уул, Гүн өндөр уул, Тосон уул, зүүн, зүүн өмнөд хэсгээрээ Их Хянганы салбар Нөмрөг, Соёлз зэрэг уул, даваа, гүвээ дов толгод оршино. Дорнод аймагт Хэрлэн, Улз, Халх, Нөмрөг, Алтан,Түргэн, Дөч, Тамсаг булаг гэх мэт гол горхи,булаг шандтай. Буйр, Сангийн далай, Хөх, Яхь, Эрээн, Галуут, Хөөвөр, Хотонт, Дэлгэр, Сумайн, Цайдам, Цагаан, Их халуун шаварт, Шорвог, Баян бүрд гэх мэт нууруудтай. Далайн түвшнээс дээш 560 метрт орших Монголын хамгийн нам доор газар Хөх нуур хэмээх тэгш тал байдаг.

Байгалийн бүс бүслүүрийн хувьд ойт-хээр, хээрийн бүс зонхилсон, 123.5 мян.км² нутагтай. Баруун, баруун хойт зүгийн агаарын урсгалаар ирэх чийгийн ихэнх нь Хэнтийн нуруунд саатдагаас Дорнод тал нутаг бол чийглэгдүү-сэрүүн, хуурайдуу-сэрүүвтэр, хуурайдуу дулаавтар уур амьсгалтай.

Баяндун сумын нутагт 2012-2021 оны хооронд дунджаар температур +0.4...+3.9°C-ын хооронд хэлбэлзсэн бөгөөд өвлийн улиралд -16.8...-14.1°C, хаврын улиралд -4.7...+11.6°C, зуны улиралд +17.1...+20.0°C харин намрын улиралд -8.9...+11.1°C хүрсэн байна. Тухайн бүс нутагт жилд орох хур тунадасны нийлбэр 161.6...555.1 мм-ийн хооронд хэлбэлзэх бөгөөд өвлийн улиралд 1.5...3.1 мм, хаврын улиралд 2.7...37.4 мм, зуны улиралд 77.2...88.9 мм, намрын улиралд 2.3...35.2 мм-ийн хооронд хэлбэлздэг. Хамгийн их хур тунадас 8 сард дунджаар 88.9 мм, хамгийн бага хур тунадас 2 сард дунджаар 1.5 мм орчим ордог байна.

Хөрсөн бүрхэвч: Судалгаанд хамрагдсан бүс нутаг нь Монгол орны хөрс-газарзүйн мужлалаар төв Азийн хөрс-био уур амьсгалын их мужийн Хангай мужийн Монголын дорнод хэсгийн Баруун Уртын 18-р тойрогт харьяалагдана.

Ашиглалтын талбайн өнгөн хөрсний ялзмагийн хэмжээ 0-12 см-ийн гүнд 2.8-4.1 % байна. Уусмалын орчин (рН) 6.4-7.4 буюу “саармаг” шинж чанартай байна. Давсжилт (0,02%) байхгүй, 0-20 см-т карбонатгүй, учраас цахилгаан дамжуулах чадвар (ЦДЧ) сул (0.04-0.05 dS/m) байна. Солилцох сууриудын нийлбэр А давхаргад 22 мг-экв/100г байж, энэхүү тоон утга тус хөрсөнд “хэвийн” байна. Шим тэжээлийн бодис болох хөдөлгөөнт фосфор 2.9-3,6 мг-экв/100г, калийн агууламж 14-40 мг-экв/100г байгаа нь уулын байгалийн нийцээр байгаа хөрсний хувьд агууламж мөн хэвийн байна. Механик бүрэлдэхүүний хувьд хөнгөн шавранцар байдаг зүй тогтоолыг лабораторийн шинжилгээний үзүүлэлт гэрчилж байна.

Ургамлан нөмрөг: Төсөл хэрэгжих талбай засаг захиргааны харьяаллаар Дорнод аймгийн Баяндун сумын нутаг ургамал-газарзүйн мужлалаар Евразийн хээрийн мужийн Дорнод Монголын хээрийн хээрийн провинцийн Улзын голын уулын хээрийн тойргийн Улзын болон Дөч голын уулын хээрийн тойрогт хамаарна (Өлзийхутаг, 1989).

Геоморфологийн онцлогийн хувьд нам бэсрэг уулс, уулс хоорондын хөндий, хоолойгоор тусгаарлагдсан толгодорхог төрх байдал гадаргын ерөнхий төрхийг бүрдүүлнэ. Бэсрэг нам

уулсын энгэр, хажуу, бэл, хормой, хөндийгөөр зүр-өвс (*Filifolium sibiricum*)-т хээр болон алаг өвс-үетэнт уулын хээрийн нугархаг хэвшил өргөн тархдаг.

Бэсрэг нам уулсын ар хормой, судаг дагаж 1-2м-ын өндөр бүхий Улиангар (*Populus tremula*), Хус (*Betula platyphylla*)-н төгөл холимог байдлаар тархах бөгөөд Улзын голын урд биеэр усны хагалбар дагаж хэсэг хэсэг төгөл тархдаг. Уулын ар хажуу, нарийн хөндийн эх дагаж Өргөст ба Дагуур Сарнай (*Rosa acicularis*, *R.dahurica*), Тавилга (*Spirea saicifolia*, *S.aquilegifolia*, *S.hypericifolia*) -ны болон Чаргай (*Cotoneaster melanocarpa*)-н зүйлүүд гэх зэрэг сөөгүүд арви өндөртэй ургана.

Амьтан: Төслийн талбайн нутаг нь амьтны аймгийн мужлалтаар Дагуур-Монголын тойрогт хамрагдаж байгаагаас харахад энд ойт хээр, хээр, нугын амьтны аймгийн бүрэлдүүнтэйгээс гадна дагуурын элемент тохиолдоно. ТЭЗҮ-д ойт хээрийн бүсэд амьдардаг буга, бор гөрөөс, гахай, цагаан зээр, чоно, үнэг, хярс, өмхий хүрнэ, тарвага, зурам, туулай, заарт харх, алаг даага, хулгана, элээ, хэрээ, тагтаа, өвөөлж, сар, ангир, хун, тогоруу, загаснаас цулбуурт, хэлтэг загас элбэг гэж бичжээ

Нийгэм эдийн засгийн байдал: Баяндун сумын нутаг дэвсгэр нь 623705 га, үүнээс бэлчээрийн газар 478411.5 га, хадлангийн талбай 33523 га, тариалангийн газар 32.4 га байна. Төв нь УБ хотоос 665 км, /Чойбалсан хотоос 176 км алслагдсан Наранбулаг суурин. Нутаг дэвсгэр нь уулын хар хүрэн, хар шороон, хужир мараат хам хөрс бүхий уулархаг гадаргатай. Бүрэн хаан (1348м), Баяндун (1298 м), Их газар (1287 м), Согоот (1229 м), Угтам (1237 м) гэх мэт уулстай.

Төслийн хугацаанд 3.5 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 2.1 тэрбум төгрөгийн зардал гаргаж, 718.63 сая төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажиллахаар байна.

3). Төслийн төлөвлөлт ба хүчин чадал

Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын уул геологийн тогтоц, хучаас хөрсний зузаан, физик механик шинж чанар зэргийг харгалзан үзэж ил уурхайн авто тээвэртэй, дотоод болон гадаад овоолготой ашиглалтын системээр ашиглахаар сонгожээ.

Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоогоор хаягдлыг уланд 1% байхаар, бохирдлыг улнаас 25 см, таазнаас 20 см байхаар тооцоход 41.14 мян.м³ буюу 54.32 % байна. Төсөл хэрэгжих хугацаанд ордоос нийт 241.04 мян.м³ хөрс хуулж, үүнээс 22.86 мян.м³ өнгөн хөрс хуулж шимт хөрсний овоолгод байршуулах бөгөөд дунджаар 192.0 мг/м³ агуулгатай шлихээр 22.44 кг, хими цэврээр 18.49 кг алттай 116.9 мян.м³ элс олборлохоор тооцооллоо.

Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоогоор 0.194 г/м³ дундаж агуулгатай В' зэргийн блокуудын нийт талбай 91.4 мян.м², хуулах хөрсний хэмжээ 241.04 мян.м³, олборлон баяжуулах элсний хэмжээ 116.9 мян.м³, нийт уулын цулын хэмжээ 357.9 мян.м³, алтны нөөц шлихээр 22.67 кг, хими цэврээр 18.68 кг тус тус болж байна. Ашигт малтмалын хучаас хөрсний зузаан 2.8 м, элсний зузаан 0.8 м, блокийн өргөн дунджаар 90 м байна.

Шороон ордын элсийг угаах төхөөрөмж нь уул-техникийн шинж чанараас хамаарч ажиллах ба зөвхөн дулааны улиралд буюу 5-р сарын 1-аас 10-р сарын 30-ийг хүртэл 180 хоног ажиллах боломжтой ба угаах тоног төхөөрөмжийн бүтээлээс хамаарч хоногт 2 ээлжээр, 10 цаг ажиллана. Ордын элсийг угаан баяжуулах цехийн жилийн хүчин чадал 116.9 мян.м³ ба

дунджаар 80мЗ хүчин чадалтай угаах төхөөрөмжийн хүчин чадлыг 60%-р тооцож ажиллах үед баяжуулах цехийн цагийн хүчин чадал 50.0мЗ байна.

4). Байгаль орчны болон нийгэм эдийн засгийн гол нөлөөллүүдийн хураангуй

Ил уурхайд хөрс хуулах, карьер үүсгэх зэргээс агаар, хөрс, ургамал, амьтан, геологийн тогтоц, байгалийн үзэсгэлэнт тогтоц, бэлчээр зэрэгт дунд нөлөөтэй байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний нэгтгэл

Эх үүсвэр	Тохиолдох магадлал	Эрчим				Нөлөөлөл зэрэг
		Нөлөөгүй	Бага	Дунд	Их	
Газрын гадарга ба хэвлий	Зайлшгүй		2	1	1	Сөрөг бага
	Боломжтой			1		
	Магадлал муу		1			
	Тохиолдохгүй					
Агаарын чанар	Зайлшгүй		1	1		Сөрөг бага
	Боломжтой		1	3		
	Магадлал муу		3			
	Тохиолдохгүй					
Гадаргын болон газрын доорх ус	Зайлшгүй			2		Сөрөг дунд
	Боломжтой		1	3		
	Магадлал муу		3			
	Тохиолдохгүй					
Хөрсөн бүрхэвч	Зайлшгүй		1	6	1	Сөрөг дунд
	Боломжтой		1	2		
	Магадлал муу					
	Тохиолдохгүй					
Ургамлан нөмрөг	Зайлшгүй			2		Сөрөг дунд
	Боломжтой		2	3		
	Магадлал муу	2	1			
	Тохиолдохгүй					
Амьтны аймаг	Зайлшгүй			2		Сөрөг дунд
	Боломжтой		2	3		
	Магадлал муу	2	1			
	Тохиолдохгүй					
Нийгэм эдийн засаг	Зайлшгүй					Эерэг дунд
	Боломжтой		4			
	Магадлал муу					
	Тохиолдохгүй					
Физикийн бохирдол, хог хаягдал	Зайлшгүй					Сөрөг нөлөөгүй дунд
	Боломжтой			3		
	Магадлал муу	3	1			
	Тохиолдохгүй					
Нийт нөлөөлөл		7	25	32	2	66
Эзлэх хувь		11%	38%	48%	3%	

5). Эрсдэлийн үнэлгээ

Уг алтны шороон ордын батлагдсан ТЭЗҮ-ийн дагуу олборлолт, баяжуулалтын технологит ямар нэгэн байдлаар химийн бодис болон тэсэлгээний хэрэгсэл ашиглахгүй тул тэдгээрээс үүсэх сөрөг нөлөөлөлгүй. Иймд энэхүү бүлэг хэсэгт төсөлд ашиглагдах тээврийн

хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдэд ашиглагдах ШТМ, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжүүдээс гарах аюултай хог хаягдал болон байгалийн гэнэтийн аюул осол зэргээс үүсч болзошгүй эрсдэлүүдийг хамруулан үзсэн болно. Төлөвлөсөн бүх хяналт менежментийн арга хэмжээнүүд, хөдөлмөр хамгааллыг чанд хэрэгжүүлсэн тохиолдолд онцгой сөрөг нөлөө байхгүй.

2.2 Төслийн гол ба болзошгүй нөлөөлөл

Агаарын чанар:

- ✓ Хөрс хуулах, олборлох үед үүсэх тоос
- ✓ Тээврийн хэрэгслийг явах үед боссон замын тоос
- ✓ Хүнд даацын машин механизм, тоног төхөөрөмжүүдийн дотоод шаталтат хөдөлгүүрийн ажиллагаанаас гарах утаа болон хий
- ✓ уурхайн малталтууд болон овоолгын дээд талбайгаас салхинд хийсэх тоос
- ✓ хөрсийг тээвэрлэх үед хийсэх тоос, шороо
- ✓ авто машинаас ялгарах хорт хий болон дизель генератор гэж үзсэн.

Хөрс: Орчны үржил шимт хөрс болон малын бэлчээр уурхайн малталтанд орж, гадаад овоолгуудад дарагдахаас гадна хүнд даацын машин техникийн үйл ажиллагаанд өртөж эвдрэлд орно.

- ✓ Нийтдээ 12,2 га талбай эвдрэлд орох нь нийт талбайн 3% эзлэж байна
- ✓ Газрын нөөц хомсдох, ухагдаж ландшафтын өөрчлөлтөд орно
- ✓ Хөрсөн бүрхэвчийн морфологи тогтоц алдагдах, үржил шим нь буурах зэргээр шинж чанар нь өөрчлөгдөнө
- ✓ Хөрс усанд угаагдаж элэгдэнэ
- ✓ Газрын гадаргуугийн төрх байдал өөрчлөгдөж хоосон орой зай үүсэх зэргээр байгалийн төрх алдагдана
- ✓ Хөрс шороо дагтарших, шаваржих, зам харгуй үүсч хөрс талхлагдана

Усан орчин: Төслөөс усны нөөцөд үзүүлэх нөлөөлөл бага байх бөгөөд уурхайн ШТМ хадгалах газар, ахуйн бохир ус, бие засах газраас нөлөөлөл учруулж болзошгүй. Уурхайн ашиглалтын явцад усны нөөцийг ашиглах мөн шавхан зайлуулснаар газар доорхи усны нөөцөд нөлөөлнө.

Ургамлан нөмрөг: Ил уурхай, хөрс, чулуулгийн овоолго хийх, уурхайн барилга байгууламж дор дарагдах зэргээр ургамлан нөмрөг хөрс хуулалттай хамт хуулагдана. ШТМ-иар ургамлан нөмрөг бохирдож, төрөл зүйлийн бүрдэлд өөрчлөлт орохоос гадна уурхайн технологийн болон гадаад тээврийн замын хөдөлгөөнөөс үүссэн тоосжилтоор зам дагуух газрын ургамлан нөмрөг бохирдох, гадаад замын трасс дагуу газар тариалан эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийн ургац тоос, шороонд дарагдаж бохирдох, улмаар ургацын чанарт сөргөөр нөлөөлнө.

Амьтаны аймаг: Автомашин, тээврийн хэрэгсэл, тэсэлгээний дуу чимээнээс ан амьтан үргэж дайжих, байршил тархалт нь өөрчлөгдөх, амьтдын амьдрах орон зай нь хумждах, уурхайн үйл ажиллагааг дагалдаж, хууль бусаар урхи, занга тавьж ан амьтан агнах, амьтны нөөц хорогдох, амьдрах орчин нь өөрчлөгдөх зэрэг сөрөг нөлөөтэй. Шатах, тослох материал хадгалах, зөөвөрлөх үед асгах, хатуу хог хаягдлыг ил задгай хаях,

эвдэрсэн газрыг хөрсжүүлэх ажил орхигдоход хөрсөнд амьдрагч сээр нуруугүйтэн, жижиг мэрэгчид, тэдгээрээр хооллогч хөхтөн, шувуудын тоо толгой цөөрөх үйл явц ажиглагдана.

Физикийн бохирдол: Дорнод аймгийн Баяндун сумын нутагт орших MV-015436 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Цагаан чулуут-1 нэртэй талбайд хамаарагдаг Цагаанчулуут худгийн “Жалга-10” “Жалга-10а” нэртэй алтны шороон ордын талбайд үйл ажиллагаа явуулаагүй байсан. Энэ нь Монгол улсад мөрдөгдөж буй Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 стандартад заасан 60 дБа-ийг даваагүй байна. Харин Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас тогтоосон зөвшөөрөгдөх дээд хэмжээ буюу 80 дБа-аас бага байна.

Хог хаягдал: Төслийн хүрээнд нийтдээ 30 хүн ажиллах ба хоногт 9 кг хог гарна. Иймд тухайн орд нь Баяндун сумын Засаг даргатай “Хог хаягдлын гэрээ”-г байгуулан ажиллах шаардлагатай.

Харин тээврийн хэрэгсэл засварын газраас урьдчилсан байдлаар дараха байдлаар хог хаягдал гарах ба ангилан кодчилсоны дагуу зориулалтын газарт тушаах

3. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний тухай жилийн гол зорилт

2024 онд “ Цагаан чулуут-1 ” алтны шороон ордын уулын ажлыг явуулахаар төлөвлөөд байна. Уурхай энэ жилд Жалга -10, Жалга -10а блокуудын талбайнуудыг олборлох ба 2В 1-1 блокоос хөрс хуулалт эхлэж нийт 214.57 мян.м³ хөрс хуулж , 113.87 мян.м³ элс олборлон баяжуулж химийн цэврээр 16,82 кг металл олборлохоор байна.

Хөрс хуулалт: Хөрсийг хуулалтанд HYUNDAI 2900LC маркийн экскаватор, тээвэрлэлтэнд Nowo маркын автосамосвалаар хөрсийг гадаад овоолгоруу тээвэрлэнэ. хөрсний овоолгыг уурхайн баруун талд байгуулахаар төлөвлөсөн ба шимт хөрсийг 0.9 га-д 5м-ийн өндөртэй байгуулна. Үндсэн хөрсний овоолгыг 0.9 га-д 10-15м- ийн өндөртэй байгуулна. 6,4 га-д дотоод овоолгоор техникийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн ба 2025-2027 онуудад биологийн нөхөн сэргээлт хийхээр БОННУ-д тусгасан болно.

3.1 Байгаль хамгаалах төлөвлөгөө

3.1.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө:

Агаар орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах:

- ✓ Овоолгын бүтцийн зүй зохистой төлөвлөлт нь хүчтэй салхи шуурганы үед босох тоосыг тодорхой хэмжээгээр багасгахад нөлөөлнө. /бууруулах./

- ✓ Тоосжилтыг бууруулах зорилгоор уурхайн үйл ажиллагааны үе шатанд замын гадаргуу болон уурхайн орчны тоосжилт их болдог газруудыг усалгааны машинаар тогтмол услаж байх. /Сэргийлэх/
- ✓ Үйл ажиллагаа явагдахаас өөр газруудад машин, техникүүдийг замбараагүй явуулахгүй байх зааварчилгааг тогтмол өгч мөрдүүлэх /сэргийлэх /

Ус, усан орчинд үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах:

- Гадаргын болон гүний усанд хамгаалалтын бүс тогтоож хамгаалалтын бүсэд мөрдөх журмыг чанд сахин ажиллах /сэргийлэх /
- Ахуйн шингэн болон хатуу хог хагдлын менежментийг хэрэгжүүлж ахуйн хатуу хаягдлаа ялган хаях /сэргийлэх /

Хөрс, ургамал, газарт үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах:

- Ил уурхай болон газар эвдэх бусад үйл ажиллагаануудыг эхлүүлэхээс өмнө шимт хөрсийг 0,2- 0,3 м зузаантайгаар хуулж авна. /бууруулах/
- Уурхайн үйл ажиллагаа эхлэхээс өмнө болон түүний явцад хуулж авсан өнгөн хөрсийг тусгайлан за ссан овоолго байдлаар хадгалах /бууруулах/

3.1 Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт 1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, сая.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт	
1	2	3	4	5	6	7	8	9		
1	Агаарын чанар									
1	Тоосжилт болон бохирдуулагч хийн нөлөөгөөр орчны агаар бохирдох, ажилчдын эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	Уурхайн технологийн замыг усалж чийглэх, (тодорхой ажлын график гаргах ба хуурайшилттай үед усалгааны хугацааг ойртуулах)	Элс болон хөрс тээврийн зам	км	-	Элс болон хөрс тээвэрлэх зам	ҮАЗ	Төсөл хэрэгжих хугацаанд өдөр бүр	ЗТБХБ-ын сайдын 2011 оны 216 тоот тушаал. MNS4585:2007	
2		Уурхайн замуудад хайрга чулуу дэвсэх зэргээр технологийн замыг сайжруулж тоос босохоос хамгаалах	Элс тээврийн зам	км	-			2024 он		
3		Уурхайн талбайд ажиллах авто тээврийн хэрэгслийн хурдыг /40км/ боломжит хэмжээгээр хязгаарлах арга хэмжээ авах	Төслийн хүрээнд	-	-	-	-	-	-	-
4		Уурхай дотор замыг тэмдэгжүүлж, засаж сайжруулж байх	Төслийн хүрээнд	Ширхэг	-	-	2.5	2024 он	Агаарын тухай хууль 9, 11, 23-р зүйл MNS 4585:2007 MNS 5919:2008	
5		Хүнд даацын машин механизмын засвар үйлчилгээг тогтмол явуулах, (бусад уурхайн жишгийн дагуу 200 мото/цаг)	Төсөлд ашиглагдах бүх авто машин	Ширхэг	-	-	6-н тээврийн хэрэгсэл	-	2024 он	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008
6	Тоосжилт хүний	Нэг бүрийн хамгаалах	Тоосжилт	-	-		ҮАЗ	2024 он	MNS 5080:2023	

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, сая.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8	9
	эрүүл мэндэд нөлөөлөх	хэрэгсэл, хүнсний нэмэлт болон хордлого тайлах бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах;	ихтэй хэсгүүдэд ажилдаг ажилчид						MNS 6768 : 2019 MNS 0012-13:91
2	Гадаргын ба газрын доорх усны нөөц								
1	Газрын доорх усанд орчны хоймстол үүсэх	Ус ашиглах гэрээг байгуулах	Төслийн хүрээнд	-	-	-	ҮАЗ	2024 он	Усны тухай хууль 31.2 зүйл Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль Усны тухай хуулийн 24.2-р заалтын
2		Ус ашиглах дүгнэлтийг холбогдох байгууллагаар гаргуулах.	Төслийн хүрээнд		-	-	ҮАЗ		
3		Ус ашигласан төлбөрийн улирал бүр төлж байх	Төслийн хүрээнд		-	-	ҮАЗ		
4		Хаягдал усны дүгнэлт гаргуулж ажиллах	Төслийн хүрээнд		-	-	ҮАЗ	2024 он	
5	Усан орчин бохирдох	Усанд агуулагдах хүнд металлын шинжилгээг хийлгэж байх	Төслийн хүрээнд		-	-	ҮАЗ	2024 он	
6		Элс угаан баяжуулахад ашиглагдаж буй эргэлтийн усан санг жил бүр засаж сайжруулж лаг шаврыг зөөвөрлөж байх.	Төслийн хүрээнд		-	-	ҮАЗ	2024 он	
7		Ус татан авах хэсэгт тоолуур суурилуулах	Усны шугам хоолойд	-	-	-	ҮАЗ	2024	
3	Хөрсөн бүрхэвч								
1	Хөрс сийрэгжих, үржил шим алдагдаж доройтох	Ашиглалтын үед хуулсан үржил шимт хөрсний овоолгыг нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний дагуу ашиглах, шимт хөрсний овоолгыг удаан хадгалахгүй	Шимт хөрсний овоолго	мян.м ³	-			2024 он шимт хөрсний овоолго хийх бүрт	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль MNS 5916:2008

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, сая.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9	
		байх.							
2	Шатах тослох материал, шатахуун асгарах зэрэг болзошгүй осол аваараас үүдэн хөрсөн бүрхэвчийг бохирдуулах	Машин механизмын эвдрэл гарсан тохиолдолд засвар үйлчилгээг хайрган хучилттай талбайд хийх	Засварын талбайд	-	-	Үйл ажиллагааны зардал		2024 он	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга
3		Ашиглагдсан тос тосолгооны материал, шатахуун асгарах, гоожих зэрэгт хяналт тавьж ажиллах, асгарсан тохиолдолд саармагжуулах арга хэмжээ авах	Ашиглалтын талбайд	-	-		1.0	2024 он	
4	Ургамлан нөмрөгт								
	Уурхайн болон ажилчдын хотхоны үйл ажиллагааны улмаас ургамлан бүрхэвч доройтох	Уурхайн тосгоны ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ширхэг мод, бут тарих	АМТЗ-ийн талбайд	ш	-	-	2.0	2024 он	Байгалийн ургамлын тухай MNS 5918: 2022.
	Уурхайн нөхөн сэргээлтэд ашиглах ургамлын үрийн фонд үүсгэх	Нөхөн сэргээлтэд ашиглах олон наст өвслөг ургамлын үрийг түүх /үр түүх ургамал тайлангийн хүснэгт 96/	Баян дун сумын нутаг	-	-	-	3.0	2024 он 8-9 сард үр түүх	Байгалийн ургамлын тухай MNS 5918: 2022. 3.10
		Нийт					8.5		

3.1.2 Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө:

2024 онд уулын ажлын төлөвлөгөөний дагуу уулын ажилд хөндөгдсөн талбайгаас 6,4 га газарт техникийн нөхөн сэргээлт хийж шимт хөрсний овоолгыг тусад нь үүсгэж байрлуулах ба нийт нөхөн сэргээлтийн зардлаа үйл ажиллагааны зардалд тусгасан .

БОННУ-д тусгасанаар 2025-2027 онуудад биологийн нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн болно.

Хүснэгт 3. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилго	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	
Уурхайн хаалтын төлөвлөгөө бэлтгэл ажил								
1	Уурхайн хаахтай холбоотой бүрдүүлэх бичиг баримт, төлөвлөлт	Уурхайн хаалтын төлөвлөгөөг боловсруулан холбогдох төрийн захиргааны төв байгууллагаар батлуулан ажиллах	-		-	ҮАЗ	2024 онд	УУ,ХҮСайд, БОАЖСайдын хамтарсан А/181, А/458 тушаал
Техникийн нөхөн сэргээлт								
1	Эврэлд өртсөн талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	Олборлолтын үйл ажиллагаа явуулсан талбайд дотоод овоолгоор нөхөн дүүргэлт хийж тэгшлэх түрэх техникийн нөхөн сэргээлт хийх	га		6.4	ҮАЗ	2024 он	”Уул уурхайн үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт, Техникийн ерөнхий шаардлага /MNS 5917-2008/
	Нийт					ҮАЗ		

3.1.3 Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 3.1.11 -д “Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэж төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг ойлгоно гэж заасан байдаг.

Ашигт малтмалын ашиглалтын нөлөөлөлд өртөж буй биологийн олон янз байдлыг тухайн газартай экологийн хувьд төстэй нөхцөлд, өөр газарт дүйцүүлэн хамгаалах ажлыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэх шаардлага бий болсон тул биологийн төрөл зүйлд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, арилгах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээг доорх хүснэгтэд үзүүлэв. Бүрэгхангай сумаас дүйцүүлэн хамгаалах ажил хийлгэх албан тоот хавсаргасан болно.

Хүснэгт 4. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Нийт зардал, сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
1	Дүйцүүлэн хамгааллын ажил хийх талбайг орон нутгийн удирдлагатай тохиролцон сонгох	Орон нутгаас зааж өгсөн булгийн эхийг хашаалж хамгаалах/Засаг Даргын албан тоотоор баталгаажсан/	Наран булгийн эхийг хамгаалах		-	ҮАЗ	2024 он	Байгаль орчны үнэлгээний тухай хууль
	Нийт					ҮАЗ		

Дорнод аймгийн Баяндун сумын нутагт орших MV-015436 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй Цагаан чулуут-1 нэртэй талбайд хамаарагдаг **Цагаанчулуут худгийн “Жалга-10” “Жалга-10a”** нэртэй алтны шороон ордын 2024 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө



Г ЭС ЖИ ГОУЛД МАЙНИНГ 7
ХХК-Д

**ДОРНОД АЙМАГ
БАЯНДУН СУМЫН ЗАСАГ ДАРГА**

4 дүгээр баг, Наран, Баяндун сум, 21120
Утас: 99561925
Цахим шуудан: bayandun.zdtg@gmail.com
Цахим хаяг: Bayandun.dornod.gov.mn

2024.05.27 № 1/154
танай 2024.05.07-ны № 05/07-т

Г Санал хүргүүлэх нь 7

Танай “Эс Жи Гоулд майнинг” ХХК /рд:5806771/-ын Дорнод аймгийн Баяндун сумын Түргэн багийн нутагт орших MV-015436 тоот тусгай зөвшөөрлийн “Цагаан чулуут-1” нэртэй талбайд хамаарагдах Цагаан чулуут худгийн “Жалга-10” “Жалга-10А” алтны шороон ордыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд дүйцүүлэн хамгаалах ажлын чиглэлээр N49°14,51461 E113°22,4643 координаттай Наранбулаг нэртэй булгийн эх хашиж хамгаалах, сэргээлгэх саналыг хүргүүлж байна.

ДАРГА  Х.ХҮРЭЛЧУЛУУН

3.1.4 Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө:

Тухайн төслийн уурхайлалтын болон эрчимтэй сөрөг нөлөөллийн бүсэд иргэд, оршин суугчид, айл өрх, байгууллага байхгүй байна. Иймд нүүлгэн шилжүүлэх төлөвлөгөө тусгагдаагүй болно.

3.1.5 Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

БОННУ-ний хээрийн хэмжилт судалгааны үеэр АМТЗ-ийн талбайд нүдэнд ил харагдах түүх соёлын дурсгалт зүйлс ажиглагдаагүй байна. Гэвч бид “Түүх соёлын өвийг хамгаалах тухай хууль”-ийг сахин биелүүлэх үүднээс хэрэв уурхайлалт болон уурхайн бэлтгэл шатны барилга байгууламж, зам талбайн ажлыг хийж байх үед газрын гүнээс түүх соёлын дурсгалт зүйл гарсан тохиолдолд нэн даруй газар шорооны ажлыг зогсоон төрийн захиргааны төв байгууллагуудад нь мэдэгдэхээр төлөвлөн ажиллах болно.

3.1.6 Химийн бодис эрсдэлийн менежментийн төлөвлөгөө:

Тус төсөл нь химийн бодис ашиглахгүй бөгөөд байгаль орчны нарийвчилсан үнэлгээний тайланд химийн бодисын эрсдэлийн үнэлгээ хийгдээгүй. Тиймээс химийн бодисын менежментийн төлөвлөгөө хийгдэх шаардлагагүй гэж үзэж байна.

3.1.7 Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө:

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хэмжээ, шаардагдах зардал, баримтлах стандартыг энд тусгана.

Хүснэгт 7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг	Нийт зардал (сая.төг)	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Байгалийн болзошгүй гамшиг, аюулт үзэгдлээс үүдэн төслийн үйл ажиллагаанд сөргөөр	Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагаа, гал түймрээс урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгаа, болзошгүй аюулын үед авах арга хэмжээг төслийн нийт ажилтан албан хаагчдад тогтмол хугацаанд танилцуулах	Төслийн нийт ажилчдад	-	2.0	2024 он	ХАБЭА

2	нөлөөлөх, дам нөлөөллөөр хүрээлэн буй орчныг бохирдуулах	“Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ”- мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэх	Төслийн хэрэгжих нийт хугацаанд	Үйл ажиллагааны төсөвт суулгах		Үйл ажиллагааны турш	ЗГ-ын 2020 оны 190-р тогтоол
3		“Гамшгийн эрсдэлийн нарийвчилсан үнэлгээ”-г үндэслэн “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө” боловсруулан батлуулж, мөрдөн ажиллах, ажилтан бүрийн ажил үүргийн хуваарийг гаргаж, зааварчилга өгөх.	Төслийн хэрэгжих нийт хугацаанд	Үйл ажиллагааны төсөвт суулгах		Үйл ажиллагааны турш	Гамшгаас хамгаалах хууль
4		Хөрсний бохирдол үүсгэх эрсдэлтэй материалын агуулахуудыг гадаргын урсаас хамгаалах ба тэдгээрээр бохирдол зөөгдөхөөс хамгаалсан далан шуудуу байгуулах	Одоо ашиглаж буй тос тосолгооны агуулах, засварын талбай ШТС	-	2.0	2024 он	
5	Шатах тослох материалын хадгалалт,	Шатах тослох материалыг стандартын шаардлага хангасан агуулахад хадгалах	Төсөлд ашиглагдах машин техник	ҮАЗ		2024 он	Химийн хортой ба аюултай бодисын тухай хууль, холбогдох журам, стандарт
6	ашиглалтаас хүний эрүүл мэнд ба хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл үзүүлэх	Шатах тослох материалын хор аюулын лавлах мэдээллийн агуулгаар сургалт хийх	Нийт ажилчид 30 хүн	ХАБЭА зардал		2024 он	
7		Ажилчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах төлөвлөлтийг хийх, хэрэгжүүлэх	Нийт ажилчид 30 хүн	ХАБЭА зардал		2024 он	
8	Үйлдвэрлэлийн гэнэтийн ослын улмаас хүний эрүүл мэнд, амь насанд сөргөөр нөлөөлж, олборлолтын үйл ажиллагаа доголдох, зогсох	Ажилчин нэг бүрийг хөдөлмөр хамгааллын хувцас, багаж хэрэгслээр хангах	Нийт ажилчид 30 хүн	ХАБЭА зардал		2024 он	MNS4990:2000 Гамшгаас хамгаалах хууль
9		Ажилчин нэг бүрт ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалсан хор тайлах зорилгоор нормын сүү, цагаан идээгээр хангах	Хүнд нөхцөлд ажиллаж байгаа ажилчдад	Үйл ажиллагааны зардлаар		2024 он	
10		Хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрэм журмыг сахиулж, хэрэгжилтэд хяналт тавих	-	Үйл ажиллагааны зардлаар		2024 он	
Нийт				4.0 +ҮАЗ+ ХАБЭА зардал			

3.1.8 Хог, Хог хаягдлын сөрөг нөлөөллийг арилгах бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа давтамж	Баримтлах хууль, журам, стандарт
1	2	3	4	5	6	7	8	9	
Ахуйн хог хаягдал									
1	Ахуйн хог хаягдлыг ангилан ялгах	Уурхайн талбай болон тосгонд стандартын шаардлага хангасан, ангилан ялгах тэмдэглэгээ бүхий хогийн сав байршуулах	Уурхайн тосгонд Уурхайн талбай Цайны газар Амралтын талбайд	ширхэг	100.0	4 байршилд	400.0	2024	Хог хаягдлын тухай хууль
2		Хог хаягдлын түр хадгалах цэгийг тохижуулах, хашаажуулах	Уурхайн хог хаягдлын цэг	-	-	-	500.0	2024 он	Хог хаягдлын тухай хууль
3		Баяндун сумын ЗДТГ-тай Хог хаягдлын гэрээ хийх.	Төслийн хүрээнд	-	-	-	-	2024 он	
4		Орон нутагтай байгуулсан хог хаягдал тээвэрлэх гэрээний дагуу ангилан ялгасан хог хаягдлыг холихгүйгээр тээвэрлүүлэх	Төслийн хүрээнд	-	-	-	1500.0	2024 он	Хог хаягдлын тухай хууль
5		Ажилчдын бие засах газрыг стандартын шаардлагад нийцүүлэх шийдвэрлэх	Төслийн хүрээнд	-	-	Хөрөнгө оруулалтын зардлаар		2024 он	
6		Уурхайн бие засах газар болон хог хаягдлын цэгүүдэд ариутгал халдваргүйжилд хийх	бие засах газар хаягдлын цэг			100.0	-	200.0	2024 он

7		Хийсэж тархсан болон үүссэн хог хаягдлыг тогтмол цэвэрлэж хэвших	Ашиглалтын талбай болон түүний ойр орчимд	-	-	-	ҮАЗ	2023-2024 он Улиралд нэг удаа	
Аюултай хог хаягдал									
1	Тээврийн хэрэгслээс гарах аюултай хог хаягдал	Ашиглагдсан тос, тосолгооны материал, аккумуляторыг тусгай цэг гарган хуримтлуулах	засварын талбайд	-	-	-	2000.0	2024 он	Хог хаягдлыг тухай хууль /шинэчилсэн найруулга/ 2017-05-12
2		Ашигласан тос тосолгооны материалыг дахин боловсруулах үйлдвэрт улиралд нэг удаа нийлүүлэх, гэрээ байгуулах	Төслийн хүрээнд				-	2024	
Нийт							4600.0		

3.1.9 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 31-р зүйл болон Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд зааснаар Цагаанчулуут худгийн “Жалга-10” “Жалга-10а” нэртэй алтны шороон орд”-ыг ил аргаар ашиглах төслийг хэрэгжүүлэхэд тухайн орон нутгийн байгаль орчныг хамгаалах, зүй зохистой ашиглах, төсөл хэрэгжиж буй орчинд бий болж болзошгүй сөрөг үр дагаврыг хянах, илрүүлэх зорилгоор


Хүснэгт 10. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Байршил	Хугацаа давтамж	Давтамж ийн тоо	Нэгжийн өртөг, мян.төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах хууль, журам, стандарт
	1	2	3	4	5	6	7	8
Агаарын чанар								
1.1	Агаар бохирдуулагчийн хэмжилт хийх	ШТМ-ын агуулах Карьерын дэргэд Элс тээврийн замын дэргэд	5-р сард 10 сард	2	-	1000.0	5 цэгт хэмжилт хийх	MNS5061:2001 MNS3113:1981 MNS0017.2.5.12:898 8
1.2	Дуу шуугианы	Уурхайн тосгон	Жилд 2	2				

хэмжилт хийх	Ил уурхай	удаа						
Хөрсөн бүрхэвч								
2.1	Хөрсний ерөнхий химийн үзүүлэлтүүдийг хянах	- Нөлөөлөлд өртөөгүй талбай - Шимт хөрсний овоолго - Нөхөн сэргээлт хийгдсэн талбай	Жилд 2 удаа	2	30.0	540.0	5 цэгт хөрсний дээжлэлт хийх -	MNS 2305-94 MNS 3298-1991 MNS 5850:2008
2.2	Нефть, нефтийн бүтээгдэхүүн, хүнд металлын агууламж микробиологийн үзүүлэлт	- Шатахуун ачих, буулгах, машин механизмыг шатахуунаар цэнэглэх талбай, агуулах орчимд - Хог хаягдал бохирын цэгийн орчимд	Жилд 2 удаа	2	30.0	540.0		
3. Усан орчин								
3.1	Ундны усны микробиологийн хяналт шинжилгээ	Унд ахуйн ус	5-р сард 10 сард	1	45.0	540.0	унд ахуйн хэрэглээний усны дээжийг кемпээс авах Угаах хэсгийн усан сангаас авах	MNS0900:1992 MNS3935:1986 MNS3936:1986 MNS4432:1997 MNS3934:1986 MNS5667-2:2001 MNS4867:1999
3.2	Усны ерөнхий химийн үзүүлэлт хүнд металлын шинжилгээ хийх	Гүний худаг Технологийн хэрэглээний ус	5-р сард 10 сард	2	45,0			
4. Ургамал								
4.1	Төслийн талбайн ургамлын төрөл, зүйл, тусгагын бүрхэц, арви, бүлгэмдлийн тархалт, талхагдлын зэргийг тодорхойлох	Төслийн талбайн 4-5 цэгт, сөрөг нөлөөлөлд өртөөгүй талбайд, нөхөн сэргээлт хийсэн талбайд, сөрөг нөлөөлөлд өртсөн талбайд гэх мэт	6 сар 8 сар	2			Бүрхцийг %-иар, арвийг тоо ширхгээр, талхагдлыг их, бага дунд гэсэг үзүүлэлтээр тодорхойлох	
5. Амьтан								
5.1	Төслийн талбай болон нөлөөллийн бүсийн амьтны мониторинг хийх	Төслийн талбайн нөлөөллийн бүст 3 цэгт ажиглалт хийх	Төслийн хугацаанд	-	-	-	Төслийн хугацаанд амьтан ажиглалтын	
6. Эрүүл мэндийн хяналт								

6.1	Ажилчдын эрүүл мэнд	Нийт ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Жилд 1 удаа	1		ҮАЗ	Эрүүл мэндийн төвтэй хамтран ажиллах	
Нийт дүн						2620.0		

Мониторингийн цэгийн байршил



3.1.10 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч “Эс жи гоулд майнинг ” ХХК жил бүр БОМТөлөвлөгөө тайлангийн хэрэгжилтийн талаар байгаль орчны асуудал эрхэлсэн терийн захиргааны төв байгууллагад тайлан хүргүүлэх ба байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, бүх шатны Засаг даргад тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил тутамд хүргүүлнэ.

Хүснэгт Удирдлага зохион байгуулалтаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, сая.төг	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2024-2028 он				
	1	2	Сар 1.2.3.	Сар 4.5.6.7,8	Сар 9.10.11	6	7
1	Байгаль орчны асуудлыг удирдлагын түвшний ажилтанд хариуцуулж, хяналт тавин ажиллах;	ҮАЗ	х	х	х	Захирал	
2	Уурхайн хаалтын төлөвлөгөөг боловсруулах мэргэжлийн байгууллагатай гэрээ байгуулах.	Гэрээний үндсэн дээр		2024			
4	Ажилтнуудад байгаль орчны сургалтуудыг ажлын байранд нь зохион байгуулж,	500.0		2024		Уурхайн дарга, БО ажилтан, Менежер	
5	Жил бүрийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө ба тайлан боловсруулах	ҮАЗ			х	Уурхайн дарга, БО ажилтан, Менежер	
6	Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааны ажлыг хийлгэх/5 жил тутамд/	Гэрээний үндсэн дээр		2024		Уурхайн дарга, БО ажилтан, Менежер	
	Нийт	500.0					

3.1.11 Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч нь нутаг дэвсгэрийн сум, багийн иргэдийн нийтийн хуралд БОМТ-ний хэрэгжилтийн талаар танилцуулгыг хагас жил тутамд хийнэ.

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацаа тов	Тайлагнах зардал мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
1	2	3	4	5	6	7	
1	Баяндун сумын 1-р багийн иргэд	ИНХ-д танилцуулах	Тухайн жилд хийгдсэн ажил	Тухайн оны 4 - р улирал	ҮАЗ	Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан	Багийн төв
2	Дорнод аймгийн Байгаль орчны газар	https://eic.mn/envmng/ буюу Байгал орчны мэдээллийн санд оруулах	Тухайн жилд байгаль орчны талаар хийгдсэн ажил нөхөн сэргээсэн ажлын акт болон холбогдох материал	Тухайн оны 11 - р сарын 1 дотор	ҮАЗ	Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан	Дорнод аймгийн төв
3	Төрийн захиргааны төв байгууллага	https://eic.mn/envmng/ буюу Байгал орчны мэдээллийн санд оруулах, тамгалуулах		Тухайн оны 12 - р сарын 1 дотор	ҮАЗ	Уурхайн дарга Байгаль орчин хариуцсан ажилтан	Төрийн захиргааны төв байгууллага
Нийт					ҮАЗ		

2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд зарцуулах нийт зардал

Д/д	Хөрөнгийн зориулалт	Хэмжих нэгж	Төлөвлөсөн Хөрөнгийн хэмжээ мян/төг	Хугацаа
1	Сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээ/ (хөрс, агаар, ургамал, ус)	мян төг	8500.0	2024 он
2	Нөхөн сэргээлтийн зардал	мян төг	ҮАЗ	2024 он
3	Дүйцүүлэн хамгаалах зардал	мян төг	ҮАЗ	2024 он
4	Осол эрсдлийн менежмент	мян төг	4000,0	2024 он
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх тухайн жилийн арга хэмжээний төсөв	мян төг	4600,0	2024 он
6	Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр	мян төг	2620,0	2024 он
7	Удирдлага-зохион байгуулалтын болон бусад арга хэмжээ	мян төг	500,0	2024 он
	Нийт зардлын дүн		20220,0₮	